



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Ард түмний хүч намын
шинэчилсэн дүрмийг бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Д.Батбаатар, Б.Батцэрэн, Г.Банзрагч, Н.Батчимэг, Н.Батзориг, М.Батсуурь, Н.Баярмаа, Э.Золзаяа, Ц.Оч, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Ундрах, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ард түмний хүч намын шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх тухай өргөдлийг шүүгч П.Соёл-Эрдэнийн танилцуулснаар хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ард түмний хүч намын дарга Л.Гүндалай нь “Тус намын 4 дүгээр Их чуулган 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хуралдаж, Улс төрийн намын тухай хуульд нийцүүлэн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн найруулж батлан хүргүүлсэн боловч Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 60 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзсан. Иймд тус намын ээлжит бус Бага чуулганы хуралдаанаар намын дүрэм (Шинэчилсэн найруулга)-д нэмэлт өөрчлөлт оруулж, Улсын дээд шүүхийн тогтоолд заасан зөрчлүүдийг арилгаж, бүртгүүлэх хүсэлтээ дахин хүргүүлсэн тул бүртгэж өгнө үү” гэсэн өргөдлийг 112 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш, 1 ширхэг сиди, 2 ширхэг фото зургийн хамт 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Улсын дээд шүүхэд ирүүлсэн байна.

Дээрх өргөдөл, хавсралт баримтуудыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга) болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 2.5-д заасны дагуу шалгах ажиллагааг хэрэгжүүлсэн ба сонсох ажиллагааны явцад нэмэлтээр 51 хуудас баримт бичиг, 1 ширхэг флаш, 1 ширхэг сиди ирүүлснийг шалгаад, журмын 6.6-д зааснаар нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлд “Нам өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-тай нийцүүлэх арга хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор авч

хэрэгжүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг Улсын дээд шүүхэд 30 хоногийн дотор хүргүүлнэ” гэж заасан.

Ард түмний хүч нам нь хуульд заасан хугацааны дотор өөрийн намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн Улсын дээд шүүхэд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр өргөдөл ирүүлсэн боловч тодорхой алдаа, зөрчилтэйн улмаас бүртгээгүй байна.

Улмаар Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар зөрчлөө зассаны үндсэн дээр дахин нэг удаа 60 хоногийн дотор намын дүрмээ бүртгүүлэх боломжийг олгосны дагуу тухайн нам нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д заасан шаардлагад нийцүүлэн дүрмээ баталсан байх тул Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ард түмний хүч намын шинэчилсэн дүрмийг бүртгэж шийдвэрлэв.

Нэг.Ард түмний хүч намын дүрэм (2023 он)-ийн 9.1.2-т “Их Чуулганыг хуралдуулах тухай шийдвэрийг Бага Чуулган 21 хоногийн өмнө гаргана”, 9.1.3-т “Их Чуулган хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэднийг сонгох журмыг Бага Чуулган тогтооно”, 9.1.5-д “Их Чуулганд сонгогдсон нийт төлөөлөгчдийн олонх нь оролцож байгаа бол Их Чуулганыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заажээ.

Өмнө нь, Ард түмний хүч намын төлөөллийн төв байгууллага болох Бага чуулган 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, 4 дүгээр Их чуулганыг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хуралдуулахаар тов тогтоосны дагуу Их чуулган хуралдаж, 06 дугаар тогтоолоор намын хөтөлбөр, дүрмийг шинэчлэн баталж, Улсын дээд шүүхэд бүртгүүлэхээр 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр ирүүлсэн байх бөгөөд хурлын процессын хувьд зөрчилгүй боловч дүрмийн зарим заалт нь “Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцээгүй” гэж 7 үндэслэл бүхий 15 зөрчлийг дурдаж, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 60 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзсан байна.

Хоёр.Дээрх 60 дугаар тогтоолын дагуу тус намын Бага чуулган 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хуралдаж, намын шинэчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн баталсан хэдий ч дүрмийн зарим заалт тодорхой бус байсныг сонсох ажиллагааны явцад тодруулсан, энэ талаар намын Бага чуулганы 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор дүрэмдээ дахин нэмэлт, өөрчлөлт оруулж, холбогдох баримт ирүүлснийг шалгахад Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцжээ. Тодруулбал,

2.1.Ард түмний хүч намын дүрмийн (хуучнаар) 9.2.2-т “Бага чуулган дараах эрх, үүрэгтэй байна”, 9.2.2.10-т “Их чуулганы чөлөөт цагт намын дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг Бага чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэх”, 9.2.4-т “Бага чуулганы хуралдааныг намын дарга, Тэргүүлэгчдийн санаачилгаар эсхүл намын Бага чуулганы гишүүдийн гуравны нэг шаардсанаар зарлан хуралдуулж болно” гэж тус тус заасан.

Ард түмний хүч намын Бага чуулганы 13 гишүүдээс намын дарга Л.Гүндалайд “Намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” санал гаргасны дагуу, намын даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “Ээлжит бус Бага чуулган зарлан

хуралдуулах, ажлын хэсэг байгуулах тухай” 01 дүгээр тушаалаар Бага чуулганы хурлыг товлон зарлаж, улмаар Бага чуулган 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр LAENNEC төвийн байранд хуралдсан байна. Тус Бага чуулганы хуралдаанд 15 гишүүн оролцсон, тус гишүүдийг Бага чуулганы гишүүн эсэхийг Улсын дээд шүүхэд хадгалагдаж буй тус намын хувийн хэргээс шалгахад, хуучин нэрээр Ард түмнээ хайрлая намын 3 дугаар Их чуулганы 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “намын Бага чуулган сонгож байгуулах тухай” 06 дугаар тогтоол, Ард түмний хүч намын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан гишүүд хуралдсан; мөн 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Бага чуулганы хуралдаан нь 14 гишүүнтэй хуралдсан болох нь тогтоогдож байх тул тухайн хурлын процесс зөрчигдөөгүй байна.

2.2. Ард түмний хүч намын дүрмийн 9.2.1-д “Намын Их чуулган нь Бага чуулганыг 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их чуулган хүртэлх хугацаагаар байгуулна. Бага чуулганы гишүүдийг сонгохдоо намын даргын саналыг харгалзан нэр дэвшүүлж, саналыг нууцаар хураана”, 9.2.6-д “Нийт гишүүдийн олонх нь оролцож байгаа бол Бага чуулганыг хүчинтэйд тооцно” гэж тус тус заасан.

Ард түмний хүч намын шинэчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Бага чуулганы 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцээд 15 төлөөлөгчийн 100 хувийн саналаар, 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Бага чуулганы хуралдаанаар хэлэлцээд 14 төлөөлөгчийн 100 хувийн саналаар тус тус дэмжсэн болох нь тус хуралдааны Тооллогын комиссын 2026 оны 03 дугаар сарын 09, 26-ны өдрийн 01 дүгээр тогтоолууд, хуралдааны тэмдэглэл болон бусад бичгийн баримтаар тогтоогдсон. Энэ нь тухайн намын хуучин дүрмийн зохицуулалтад нийцжээ.

2.3. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 17 дугаар зүйлийн 17.4-т “Намын төлөөллийн төв байгууллагын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь санал гаргавал намын дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно. Энэ нэмэлт, өөрчлөлт нь намын дүрмийн гуравны нэгээс хэтрэхгүй байна” гэж заасан.

Өмнөх, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 60 дугаар тогтоолоор бүртгэхээс татгалзсан, Ард түмний хүч намын 4 дүгээр Их чуулганы 06 дугаар тогтоолоор баталсан намын шинэчилсэн дүрэм нь 172 хэсэг, 146 заалт бүхий нийт 318 асуудлыг зохицуулсан байсан ба 7 үндэслэл бүхий 15 зөрчлийг засаж, Бага чуулганы 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаар, Бага чуулганы 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар тогтоолоор дээрх дүрэмд 27 хэсгийг шинээр нэмж, 3 хэсэгт нэмэлт оруулж, 15 хэсэгт өөрчлөлт оруулж, 2 хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж, 2 хэсэгт хасалт хийж, нийт 49 асуудалд дүрмийн 15.4 хувь болох нэмэлт, өөрчлөлт хийсэн нь Улс төрийн намын тухай хуулийн 17.4-т заасантай нийцэж байна.

Гурав. Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Намын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоог энэ хуульд заасны дагуу намын дүрмээр зохицуулна”, 15.2-т “Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана” гээд 15.2.1-15.2.10-т намын дүрэмд тавигдах шаардлагыг тодорхойлжээ. Тодруулбал,

3.1.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-т “намын удирдах дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага, хяналтын байгууллага болон бусад байгууллага, тэдгээрийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ, хуралдуулах, шийдвэр гаргах журам” гэж заасан, намын дүрмийн 9.1-д “Намын удирдах дээд байгууллага нь намын Их хурал мөн бөгөөд дөрвөн жилд нэгээс доошгүй удаа хуралдана”, 9.4-т “Намын Их хурлын ээлжит болон ээлжит бус хуралдааны тов, төлөөлөгчдийн тоо, тэднийг сонгох журам, хэлэлцэх асуудлыг Бага хурал тогтооно”, 10.2-т “Намын Бага хурлыг намын Их хурлаас 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар нууц санал хураалтаар сонгоно ...”, 11.1-д “Намын Бага хурлын чөлөөт цагт намыг шуурхай удирдлагаар хангах намын гүйцэтгэх төв байгууллага нь Тэргүүлэгчид мөн бөгөөд намын Бага хурлаас дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар сонгоно ...”, 11.2-т “Бүрэлдэхүүнд албан тушаалын зарчмаар намын дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга болон сонгуулийн зарчмаар Бага хурлын хуралдааны үед чөлөөт нэр дэвшилтээр 3 гишүүн нууц санал хураалтаар сонгогдоно”, 13.2-т “Дүрмийн хороог намын Их хурлаас 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дөрвөн жилээс илүүгүй хугацаагаар ... чөлөөт нэр дэвшилтээр саналаа нууцаар хурааж тус тус сонгоно ...” гэж эдгээр байгууллагыг хуралдуулах, хурлын тов тогтоох, зар мэдэгдэх, хурал хүчин төгөлдөр болох нөхцөл, шийдвэр гаргах, санал хураалтын журам, мөн тус хурлын бүрэлдэхүүнд нэр дэвших, сонгох, сонгогдох болон бүрэлдэхүүнийг чөлөөлөх, огцруулах үндэслэл журмын талаар тус тус зохицуулжээ.

3.2.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан “намын гишүүнээр элсэх, намын гишүүнээс түдгэлзэх, намын гишүүний эрх, үүрэг, намын гишүүнээс хасах болон бусад сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл”-ийг намын дүрмийн 3 дугаар зүйлд намын гишүүнээр элсэх, 4 дүгээр зүйлд намын гишүүний эрх, үүрэг, 6 дугаар зүйлд намын гишүүнээс түдгэлзэх, 7 дугаар зүйлд намын гишүүнээс гарах, хасах зэрэг зохицуулалтыг заасан байна.

3.3.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасан “намын даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх хэмжээ”-г намын дүрмийн 12.2-т “Намын даргыг намын Бага хурлын хуралдааны үед чөлөөт нэр дэвшилтээр дөрвөн жилийн хугацаагаар нууц санал хураалтаар сонгож, намын Их хурлаас ёсчлон батламжлахаар, дүрмийн 12.3-т түүний бүрэн эрх, даргад нэр дэвших, сонгох, сонгогдох, чөлөөлөх, огцруулах талаар ерөнхийлөн зохицуулсан.

3.4.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.9-д заасан “намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг дүрмийн 17 дугаар зүйлд намын хөрөнгө, орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах гэж, 17.1-д намын орлого нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, гишүүний татвар, хандив, намын өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого, хуулиар зөвшөөрсөн бусад орлогоос бүрдэхээр зохицуулсан байна. Мөн дүрмийн 17.18-д төрөөс олгох санхүүгийн дэмжлэгийн талаар тусгажээ.

Иймээс, Ард түмний хүч намын шинэчилсэн дүрэм нь бүхэлдээ хуулийн 15 дугаар зүйлд заасан намын дүрэмд тавигдах нийтлэг шаардлага болон намын дүрмээр тусгайлан зохицуулах асуудлыг тусгасан нь Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцсэн байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн 15 дугаар зүйлийн 15.3, 15.5 дахь заалтыг баримтлан Ард түмний хүч намын шинэчилсэн дүрмийг бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ